БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр Дугаар А/01 Чихэртэй

Салбар дэд хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Е.Аххундыз - Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч

Гишүүд: А.Яков - Хөдөө, аж ауйн тасгийн мэргэжилтэн
А.Дарига - Архив, бичиг хэргийн эрхлэгч
А.Мурат - Төрийн нэгдсэн лавлагаа, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга: Ж.Нурсулу - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Е.Аххундыз, Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ж.Нурсулу нарт даалгасугай.

ОРЛОГЧ О.АДАЛБЕК

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/02 Чихэртэй

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, 52.7, 52.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн иргэн Салдатын Тойлат болон тус багийн иргэд Талгат, Ыхылас нарын бэлчээрийн маргааныг газар дээр нь очиж танилцаж, шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: И.Амантай - Газрын даамал

Гишүүд: А.Яков - Хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн
С.Талгат - Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
М.Аххазы - Багийн иргэдийн нийтийн хурлын хуралдааны дарга

Нарийн бичгийн дарга: А.Ахтан - Багийн Засаг дарга

2. Уг маргааныг зохих хууль журмын дагуу, шийдвэрлэн ажиллахыг ажлын хэсгийн дарга -д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ О.АДАЛБЕК

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/03 Чихэртэй

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 43.4 дэх заалтыг тус тус үндэслэн, Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/414 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 5 дугаар багийн нутаг дэвсгэр болох Мухар даваатын амны Сагсайн голд баригдах "Хар мудаагийн модон гүүрийн барилгын угсралтын" ажлыг хүлээж авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: И.Амантай - Газрын даамал
К.Исламбек - Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч
Б.Тилек - Байгаль хамгаалагч
А.Муратбек - Төрийн нэгдсэн лавлагаа, мэдээлэл технологийн ажилтан
А.Нурбек - Гүйцэтгэгчийн төлөөлөл
Нарийн бичгийн дарга - К. Исламбек.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 5 дугаар багийн нутаг дэвсгэр болох Мухар даваатын амны Сагсайн голд баригдах "Хар мудаагийн модон гүүрийн барилгын угсралтын" ажлыг хүлээж авах ажлыг зураг төсвийн дагуу хийгдсэн байдалд хяналт тавьж, зохих хууль тогтоомжийн дагуу хүлээж авах ажлыг зохион байгуулан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ Ө.АДАЛБЕК

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/04 Чихэртэй

Золбин нохой болон үхсэн малын
цэг, зэм устгах, хөрөнгө
зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Мал амьтан, эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтнаас хүнд халдварлах зооноз өвчин, амьтнаас малд халдварлах халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус сумын нутаг дэвсгэрт буй зүй бусаар хоригдсон малын цэг, зэм болон золбин нохой болон жингэр нохойг устгах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулсугай.

2. Золбин нохойг устгах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: К.Исламбек - Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч

Гишүүд:
С.Шаймардан - Засаг даргын Тамгын газрын нярав
М.Ерханат - Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
А.Яков - Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Е.Жарденбек - Тархвар зүйч
Б.Тилек - Байгаль хамгаалагч
А.Серикжан - Засаг даргын Тамгын газрын жолооч
А.Ахтан - 1 дүгээр багийн Засаг дарга
Х.Батхүү - 2 дугаар багийн Засаг дарга
Х.Хумырбек - 3 дугаар багийн Засаг дарга
Х.Танатар - 4 дүгээр багийн Засаг дарга
Г.Сугар-эрдэнэ - 5 дугаар багийн Засаг дарга
Д.Сүхээ - Цагдаагийн хэсгийн цагдаа ахлах ахлагч

С.Хибат - Манаач

Х.Жандос - Манаач

С.Аманжол - Манаач

С.Энхбат - 4 дүгээр багийн иргэн

3. Сумын төвийн бүх айл өрхүүдийн хоточ нохойг гэрчилгээжүүлэн, тулгалт хийлгэн, мөн өргөдөл гомдол ирсэн эзэнтэй болон эзэнгүй бүх золбин нохой, жингир нохой устгах ажлыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулж хийсэн ажлын талаарх мэдээллийг удирдах, гүйцэтгэх ажилтнуудын шуурхай хуралд тайлагнахыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Золбин нохойг устгах, Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажилд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган гарсан зөрчлийг арилгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга бөгөөд Улсын байцаагч К.Исламбек-т үүрэг болгосугай.

5. Золбин нохой устгах ажилд шаардагдах хөрөнгийг Орон Нутгийн Хөгжлийн Сангийн золбин нохой устгах арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Адебиет-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Е.Аххундыз-д даалгасугай.

ОРЛОГЧ О.АДАЛБЕК

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/05 Чихэртэй

Цасны хэмжээг тогтоох, хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 32.1.1, 32.1.3, 32.1.7, 32.1.8, 32.1.10, 32.1.10, 32.1.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын хурлаас гарсан шийдвэрийн дагуу өвөлжилт хүндэрсэн, хүндрэх төлөвтэй байгаа багуудын газар нутгийн цасны зузааны хэмжээг газар дээр нь авч судалгааг хүргэх, малчин иргэдийн амьдрал байдалтай танилцаж сумын удирдлагуудыг мэргэжлийн хүний хамт ажиллуулж хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх ажлыг хийж гүйцэтгэх сумын удирдлагуудыг ажиллуулахад Улаанхад багт А/92 бензин 80лх2980=238.400 (хоёр зуун гучин найман мянган дөрвөн зуун) төгрөг, Борбургас багт А/92 бензиний үнэ 60х2980=457.200 (дөрвөн зуун тавин долоон мянган хоёр зуун) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх зардлаас гаргахыг Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Адебиет-д зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ Г.Л О.АДАЛБЕК